



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

# **ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ**

**Дугаар 2020/04**

**Улаанбаатар хот  
2020 он**

## ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Аж үйлдвэр	2
2. Мал аж ахуй	4
3. Газар тариалан	7
4. Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ	8

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

## 1.АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 4 сард урьдчилсан гүйцэтгэлээр 4.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (24.1%) их наяд төгрөгөөр буурлаа.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2020\* оны эхний 4 сард



Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.3 (33.0%) их наяд төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 65.1 (6.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 4 дүгээр сард 925.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 55.5 (5.7%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 32.8 (5.2%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 13.0 (5.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт 2020 оны эхний 4 сард гурил, шингэн сүү, ус, ундаа, жүүс, спирт зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 14.5-32.7 хувиар өссөн байна.

**БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар**

Дэд салбар	2019		2020*		<u>2020* I-IV</u>
	IV	I-IV	IV	I-IV	2019 I-IV
	сая төгрөг				хувь
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>302 998.8</b>	<b>1 005 486.0</b>	<b>213 700.5</b>	<b>940 435.9</b>	<b>93.5</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	126 906.4	483 328.9	114 384.6	499 380.8	103.3
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	13 698.8	65 433.3	14 463.8	46 924.7	71.7

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21 170.3	73 611.4	20 781.8	74 751.7	101.5
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	16 140.6	66 199.9	20 495.9	75 108.9	113.5
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18 202.6	63 727.4	17 642.9	71 517.1	112.2
Ундааны үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	57 694.2	214 356.9	41 000.1	231 078.4	107.8
Тамхины үйлдвэрлэл	1 712.4	4 945.0	2 525.7	2 743.5	55.5
Нэхмэлийн үйлдвэрлэл	80 057.9	184 545.0	21 501.1	108 639.7	58.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	3 035.7	11 548.8	1 322.7	6 770.2	58.6
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	2 561.7	6 970.5	2 239.5	8 486.9	121.8
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	978.7	4 641.3	1 270.1	4 570.9	98.5
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 749.0	10 528.3	2 761.6	12 794.8	121.5
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	3 460.5	10 496.3	2 811.5	12 528.8	119.4
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	12 680.8	50 496.2	10 874.7	42 749.6	84.7
Резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 737.4	8 385.0	1 957.3	7 211.1	86.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	20 618.2	46 312.8	19 770.6	32 357.8	69.9
Төмрийн үйлдвэрлэл	22 590.4	70 471.8	20 098.7	69 740.4	99.0

Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	306.3	1 580.6	383.0	1 143.2	72.3
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	10.9	720.4	29.1	877.5	121.8
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	49.4	115.3	41.7	275.0	2.4 <sup>1</sup>
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	1 316.1	4 851.9	775.6	2 727.2	56.2

## 2.МАЛ АЖ АХУЙ



Улсын хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 31.0 сая хээлтэгч малын 18.8 сая (60.8%) нь 2020 оны эхний 4 сард төллөсөн байна.

Эм хонины 68.0 хувь, эм ямааны 61.3 хувь, ингэний 35.2 хувь, үнээний 34.0 хувь, гүүний 19.6 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 96.1 хувь буюу 18.1 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 214.1 (1.2%) мянгаар өссөн байна.


Төл бойжилт, төрлөөр, хувиар, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Эх малын төрөл	Төллөсөн хээлтэгч				Төллөлтийн хувь			
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
	мянган толгой				хувь			
<b>Бүгд</b>	<b>17114.3</b>	<b>14719.2</b>	<b>18294.7</b>	<b>18822.8</b>	<b>64.6</b>	<b>52.1</b>	<b>61.4</b>	<b>60.8</b>
Гүү	224.5	216.6	247.7	272.1	20.2	17.7	19.2	19.6
Үнээ	512.6	494.0	517.5	645.4	32.3	28.9	29.5	34.0
Ингэ	45.6	45.5	47.4	58.9	32.7	30.1	29.5	35.2
Эм хонь	8955.3	8160.2	9919.3	10022.2	71.2	60.4	69.7	68.0
Эм ямаа	7376.3	5802.9	7562.8	7824.2	66.7	49.9	61.3	61.3


## Төл бойжилт, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 4 сард

Төлийн төрөл	Бойжуулсан төл				Төл бойжилт			
	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV
	мянган толгой				хувь			
<b>Бүгд</b>	<b>16 826.9</b>	<b>14 107.0</b>	<b>17 890.1</b>	<b>18 104.2</b>	<b>98.1</b>	<b>95.6</b>	<b>97.6</b>	<b>96.1</b>
Унага	220.6	209.1	242.7	264.6	98.3	96.5	98.0	97.2
Тугал	503.3	479.4	509.5	630.1	98.2	97.0	98.5	97.6
Ботго	45.3	45.0	47.0	58.3	99.2	98.9	99.0	99.0
Хурга	8 833.0	7 893.9	9 723.2	9 630.5	98.5	96.4	97.9	96.0
Ишиг	7 224.6	5 479.6	7 367.7	7 520.7	97.7	94.2	97.2	96.0

## Төл бойжилт, төрлөөр, хувиар, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний 4 сард улсын хэмжээнд 923.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 481.6 (2.1 дахин) мянгаар нэмэгдсэн байна. Харин 2020 оны 4 дүгээр сард 365.1 мянган толгой мал хорогдсон нь эхний 4 сард хорогдсон малын 39.6 хувийг эзэлж байна.



Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, хонь 480.3 мянга, ямаа 342.7 мянга, үхэр 63.1 мянга, адуу 36.8 мянган толгой, тэмээ 285 толгой хорогдсон байна. Нийт хорогдсон малын 52.0 хувийг хонь, 37.1 хувийг ямаа эзэлж байна.

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2020 оны эхний 4 сард Архангай аймагт 254.1 (27.5 хувь) мянга, Хөвсгөл аймагт 243.8 (26.4 хувь) мянган толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 53.9 хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон 31.0 сая эх малын 184.3 мянга (0.6%) нь 2020 оны эхний 4 сард хорогдсон байна. Завхан, Хэнтий, Булган, Хөвсгөл, Архангай аймгуудад хээлтэгч мал 15.4-56.8 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 79.4 хувийг эзэлж байна. Харин 29.7 мянган толгой хээлтүүлэгч мал хорогдсны 13.4 мянган ухна, 13.3 мянган хуц, 2.3 мянган бух, 663 толгой азарга, 17 толгой ат байна. Улсын хэмжээнд 2020 оны эхний 4 сард 21.6 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 12.6 (2.4 дахин) мянгаар өссөн байна.

Хорогдсон нийт том малын 2.3 хувь нь өвчнөөр, 8.2 хувь нь аюулт үзэгдлээр, 89.4 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асганаас унах, өлдөх, даарах зэрэг шалтгааны улмаас хорогдсон байна.

## 3.ГАЗАР ТАРИАЛАН



Хаврын тариалалтад бэлэн байгаа буудайн үр 2020 оны 5-р сарын 1-ний байдлаар 40.9 мянган тонн байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.5 (5.7%) мянган тонноор буурсан байна.

Хаврын тариалалтад бэлэн байгаа буудайн үрийн хэмжээ,  
5-р сарын 1-ний байдлаар, мянган тонн

	2017.V	2018.V	2019.V	2020.V	<u>2020.V</u> <u>2019.V</u>
	мянган тонн				хувь
Нийт үрийн хэмжээ	53.7	63.2	43.4	40.9	94.3
Иргэд, ААНБ	42.3	30.6	32.0	33.4	104.2
Бусад	11.4	32.6	11.4	7.5	66.4

Харин энэ оны 5-р сарын 1-ний байдлаар, өргөн холбооны 96.4%, бүх төрлийн сийрүүлэгчийн 95.6%, дугуйт тракторын 94.3%, гинжит тракторын 79.7% нь хөрс боловсруулалт, тариалалтад ажиллахад бэлэн болсон байна.

Хөрс боловсруулалт, тариалалтад ажиллах, зарим техникийн бэлэн байдал,  
5-р сарын 1-ний байдлаар, хувиар


	2017.V	2018.V	2019.V	2020.V
	хувь			
Өргөн холбоо	93.2	96.0	93.9	96.4
Бүх төрлийн сийрүүлэгч	93.0	94.6	86.7	95.6
Дугуйт трактор	85.8	87.0	90.1	94.3
Гинжит трактор	75.7	69.7	80.4	79.7
Анжис	93.0	92.7	93.6	96.9
Бул	94.5	89.0	91.7	92.3
Төмс, хүнсний ногооны үрлүүр	89.5	92.6	85.4	96.1



#### 4.ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 4 дүгээр сард ат 1.1 сая төгрөг, хязаалан гуна 1.0 сая төгрөг, соёолон үрээ 867.9 мянган төгрөг, эр хонь 165.0 мянган төгрөг, эр ямаа 120.2 мянган төгрөг байна.

Нас гүйцсэн малын дундаж үнэ, жил бүрийн 4 дүгээр сард, мянган төгрөгөөр




Малын аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 4 дүгээр сард цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ Сүхбаатар аймагт хамгийн их буюу 61.5 мянган төгрөг, Баян-Өлгий аймагт хамгийн бага буюу 35.5 мянган төгрөг байна.

Ямааны цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ, 2020 оны 4 дүгээр сард, аймаг, нийслэлээр, төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 4 дүгээр сард үхрийн 2 метрээс дээш урттай шир 4.7 мянган төгрөг, ямааны цагаан ноолуур кг-ын үнэ 47.9 мянган төгрөг байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ,  
жил бүрийн 4 дүгээр сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 4 дүгээр сард боодолтой өвсний (20кг) үнэ Дундговь аймагт хамгийн их буюу 14.3 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 4.5 мянган төгрөг байна.

Боодолтой өвсний дундаж үнэ,  
2020 оны 4 дүгээр сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 4 дүгээр сард 25 кг хивэгний үнэ Өмнөговь аймагт хамгийн их буюу 17.7 мянган төгрөг, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 13.0 мянган төгрөг байна.